



ГАЦУУРТЫН УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

ОЛОН НИЙТЭЭС САНАЛ АВАХ ТӨСӨЛ. ОЛОН НИЙТИЙН САНАЛЫГ ТУСГАСАН ЭЦСИЙН ХУВИЛБАРЫГ ТӨСЛИЙН САНХҮҮЖИЛТ ЭХЛЭХИЙН ӨМНӨ БОЛОВСРУУЛНА.

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------|----------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| ГШ1 | Байгаль орчин, Нийгмийн нөлөөллүүдийн Үнэлгээ ба Мененжмент | | | | | | |
| 1.1 | Төслийн байгаль орчин, нийгмийн ¹ гүйцэтгэлүүд, ба энэхүү Байгаль орчин, Нийгмийн Үйл Ажиллагааны Төлөвлөгөөний (БОНУАТ) хэрэгжилтийн талаарх Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн тайланг ЕСБХБ-д хүргүүлэх. | ЕСБХБ -ны тайлангийн шаардлага | ЕСБХБ ГШ1 | Компанийн ² нөөц | Барилгын үе шатанд: Байгаль орчин, нийгмийн тайлан ба БОНУАТ-ний явцыг ЕСБХБ-д улирал бүр хүргүүлнэ. Үйл ажиллагааны үе шатанд: ЕСБХБ-ны зээлийн үргэлжлэх хугацааны туршид Байгаль орчин, нийгмийн жилийн тайлан ба БОНУАТ-ний явцыг компаний санхүүгийн жил дууссанаас 60 хоногийн дотор ЕСБХБ-д хүргүүлнэ. | Байгаль орчин, нийгмийн (ЕСБХБ-ны загвараар хийгдсэн) болон БОНУАТ-ний явцын тайлангууд. БОНУАТ-ий тайлан болон явц нь ЕСБХБ-шаардлагуудыг хангасан байна. | |

¹ 'Байгаль орчин, Нийгэм' гэдэгт ажлын байрны ба олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал болон хүний нөөц, ажиллах орчны асуудлууд орно.

² Сентерра Гоулд

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|--------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| 1.2 | <p>Шаардлагатай бол Төслийн Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны (ЭМААБО) менежментийн систем болон холбогдох журмуудад (уурхайн барилга, ашиглалт, хаалтын үе шатуудад) нэмэлт өөрчлөлт хийх, шинэчлэх арга хэмжээ авах.</p> <p>ЭМААБО-ний менежментийн систем, журмууд, менежментийн төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай нөөц бололцоогоор хангах.</p> | <p>Тохирсон менежментийн системийг боловсруулан хэрэгжүүлснээр Байгаль орчин, нийгмийн асуудлуудын зохистой менежмент хийх</p> | <p>ЕСБХБ ГШ 1, Тэргүүн туршлага</p> | <p>Компанийн нөөц</p> <p>Ажил, үүргийн хуваарилалт</p> | <p>Холбогдох үе шатны ажлууд (барилгын, ашиглалтын үйл ажиллагаа болон хаалт) эхлэхээс өмнө зохих шинэчлэлт, нэмэлт өөрчлөлтүүд хийгдсэн байна.</p> <p>Шаардлагатай үед хэрэгжүүлнэ.</p> | <p>ЭМААБО-ний менежментийн системийн шинэчлэл, өөрчлөлтүүд нь Төсөлтэй уялдуулан боловсруулагдсан байна.</p> <p>ЭМААБО-ний менежментийн системийг төслийн бүхий л хугацаанд (барилгын, ашиглалтын үйл ажиллагаа болон хаалт) мөрдөн хэрэгжүүлнэ.</p> <p>ЭМААБО-ний менежментийн системийг хэрэгжүүлэхэд нөөц бололцоогоор хангасан байна.</p> | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-----|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| 1.3 | Төслийн Байгаль орчин, Нийгмийн нөлөөллийн үнэлгээний (БОННУ) хэсэг болгон боловсруулсан Байгаль орчин, Нийгмийн менежментийн болон хяналт шинжилгээний төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж Төслийн ЭМААБО менежментийн системд нэгтгэх. | Тохирсон менежментийн систем, хяналт шинжилгээний төлөвлөгөөг хэрэгжүүлснээр Байгаль орчин, нийгмийн асуудлуудын зохистой менежмент хийх | ЕСБХБ ГШ 1, Тэргүүн туршлага | Компанийн нөөц. Шаардлагатай тохиолдолд гадны зөвлөхүүд авах. Ажил, үүргийн хуваарилалт. | Холбогдох үе шатны ажлууд (барилга, ашиглалт болон хаалт) эхлэхээс өмнө хийгдсэн байна. | Байгаль орчин, нийгмийн менежмент, хяналт шинжилгээний төлөвлөгөөнүүдийг бүрэн боловсруулж хэрэгжүүлсэн байна. | |
| 1.4 | Гэрээт ажиллагсад, ханган нийлүүлэгчдийн үйл ажиллагаанаас үүсэх Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн эрсдлийн менежментийн холбогдох заалтуудыг тендер, гэрээ, компанийн хяналт шинжилгээ, болон гэрээлэгч, ханган нийлүүлэгчдийн гүйцэтгэлийн аудитад оруулах. | Гэрээлэгч талуудын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, хөдөлмөрийн эрсдлийн менежмент ба хяналт шинжилгээ. | ЕСБХБ ГШ 1, ГШ 2 Тэргүүн туршлага | Компанийн нөөц. Ажил үүргийн хуваарилалт | Гэрээт ажиллагсад, ханган нийлүүлэгчдийг сонгохоос өмнө бэлэн болсон байна. Менежмент болон хяналт шинжилгээг гэрээний хугацаанд гүйцэтгэнэ. | Гэрээлэгч болон ханган нийлүүлэгчдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, хөдөлмөрийн эрсдлийн менежменттэй холбоотой зүйл заалтууд тодорхой болсон байна. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------|--------|
| 1.5 | Тодорхой хугацаанд шинэчлэгдэн боловсруулагдаж байх уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөөтэй байх. Хаалтын үйл ажиллагаанд шаардагдах зардалтай холбоотой заалтуудыг төлөвлөгөөнд оруулсан байх. | Уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн менежмент | ЕСБХБ ГШ 1, ГШ 3, ГШ 6 | Компанийн нөөц Шаардлагатай тохиолдолд гадны зөвлөхүүд авах | Гурван жил тутамд шинэчлэл хийх ба нарийвчилсан төлөвлөгөөг хаалт хийхээс гурван жилийн өмнө боловсруулсан байна. | Зардлын тооцоо бүхий уурхайн хаалт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулсан байна. | |
| 1.6 | Уурхайн үйл ажиллагаа нь нийгэм-эдийн засгийн ашиг тусаа тогтвортой өгч байх, уурхай хаагдсаны дараа ч нийгэм-эдийн засгийн хувьд эерэг үл мөр үлдээхэд нь Нийгмийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг чиглүүлэх Орон нутгийн хөгжлийн менежментийн төлөвлөгөөг нутгийн иргэд, холбогдох оролцогч талуудын оролцоотойгоор боловсруулах. | Уурхайн үйл ажиллагаа нь нийгэм-эдийн засгийн ашиг тусаа өгч байх, уурхай хаагдсаны дараа ч нийгэм-эдийн засгийн эерэг үл мөр үлдээж байх. | Тэргүүн туршлага | Компанийн нөөц | Уурхайн ашиглалтын үе шатнаас эхлэн үргэлжлэх | Орон нутгийн хөгжлийн менежментийн төлөвлөгөө ба Нийгмийн хөгжлийн сан бий болсон байна. | |
| 1.7 | Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ, Нийгмийн Менежментийн Төлөвлөгөөнд тодорхойлогдсон Гацуурт дахь бичил уурхайн асуудлаарх нэмэлт арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх. | Бичил уурхайн асуудлын зохистой менежмент | Тэргүүн туршлага | Төрийн байгууллагууд -ын дэмжлэг. Компанийн нөөц | Уурхайн барилгын үе шатнаас эхлэн үргэлжлэх | Гацууртын төсөлтэй холбогдох бичил уурхайн асуудлуудын зохистой менежмент бий болсон байна.. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| ГШ2 | Хөдөлмөр ба Ажлын Нөхцлүүд | | | | | | |
| 2.1 | Компанийн болон гэрээт ажиллагсадын хүний нөөцийн бодлогын заалтууд, ажиллах нөхцлүүд нь Гүйцэтгэлийн Стандарт 2 болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжуудтай нийцсэн байх. | Компанийн болон гэрээт ажиллагсдын эрсдлийн зохистой менежмент | ЕСБХБ ГШ 2, Хөдөлмөрийн хууль | Компанийн нөөц | Уурхайн барилгын өмнөх шатнаас эхлэн уурхайн бүхий л үе шатанд үргэлжлэх | Компанийн хүний нөөцийн бодлого, ажиллагсадын ажиллах нөхцлүүд нь Гүйцэтгэлийн Стандарт 2 болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжуудад нийцсэн байна. Компанийн хүний нөөцийн шаардлагуудыг гэрээт ажиллагсад мөн мөрдөнө. | |
| 2.2 | Компани болон болон гэрээт компаниуд нь ЕСБХБ-ны ГШ 2 болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжуудын шаардлагуудыг хангаж байгаа эсэх талаар хяналтыг тодорхой хугацаанд хийх | Компанийн болон гэрээт компаниудын хөдөлмөрийн үйл ажиллагааны эрсдлүүдийн зохистой менежмент | ЕСБХБ ГШ 2 | Компанийн нөөц Шаардлагатай тохиолдолд гадны зөвлөхүүд авах | Барилгын үйл ажиллагаа (жилд 2 удаа) болон уурхайн ашиглалтын үе шатанд (жилд 1 удаа) | Ажиллагсдын болон гэрээт ажиллагсдын аудитын тайлангууд гарсан байх. Компанийн болон гэрээт ажиллагсдын Хүний нөөцийн бодлогын холбогдох заалтууд нь ГШ 2 болон Монгол улсын хөдөлмөрийн хууль тогтоомжуудтай нийцсэн байна. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-----|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|----------------------------------------|----------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| 2.3 | Бороогийн уурхай дээр байгаа болон шинээр баригдах компанийн болон ажиллагсдын байрлах кемп/байрны нөхцлүүд нь “ОУСК/ЕСБХБ-ны Ажиллагсдын байр: процесс ба стандартууд” удирдамжийн шаардлагуудыг хангаж байх. | Ажиллагсад/ гэрээт ажиллагсдын Орон байртай холбоотой эрсдлийн менежмент | ЕСБХБ ГШ 2 | Компанийн нөөц Гэрээлэгч талууд | Кемп/Сууц орон барих болон ашиглах хугацаанд | Ажиллагсад/ Гэрээт ажиллагсдын кемп/байр нь “ОУСК/ЕСБХБ-ны Ажиллагсдын байр: процесс ба стандартууд” удирдамжийн шаардлагуудыг хангасан байдлаар баригдаж ашиглагдана. | |
| 2.4 | Ажиллагсад/гэрээт ажиллагсдын өргөдөл, гомдол барагдуулах албан ёсны механизмыг боловсруулж Төсөлд ашиглана. Энэ механизм нь хүн бүр ашиглах боломжтой байхын зэрэгцээ, шаардлагтай бол гомдол гаргачдын нууцлалыг хамгаалсан байх бөгөөд хүлээн авсан өргөдөл гомдлыг хянах, барагдуулах хугацаа, процесс ил тод ойлгомжтой байна. | Ажиллагсад санал гомдлоо гаргах аргууд, өргөдөл гомдол шийдвэрлэх ил тод, тууштай механизмуудээр хангагдана. Ажиллагсдын менежмент сайжирна. | ЕСБХБ ГШ 2 | Компанийн нөөц | Уурхайн барилгын болон ашиглалтын үе шатанд | Ажиллагсдын өргөдөл гомдлын үр дүнтэй менежмент бий болсон байна. Хүлээн авсан өргөдөл гомдол, тэдгээрт өгсөн хариуг баримтжуулсан байна. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------|----------------------------------|------------------------|---------------------------------------------------------------------|--------|
| 2.5 | <p>Зөрчил маргаан шийдвэрлэх, олон нийтийн жагсаал цуглааны үеийн менежмент, хамгаалалтын үйл ажиллагаа ба хүч хэрэглэх (зөвшөөрөгдсөн үед) үеийн хэм хэмжээ, хүний эрхийн үндсэн заалтуудыг Аюулгүй байдал, хамгаалалтын бодлогод тусгасан байх.</p> <p>Сургалтын бичиг баримтуудыг баримтжуулан хадгалах.</p> <p>Ажилд орж буй хүмүүс гэмт хэрэг, хүний эрхийг зөрчсөн аливаа үйл ажиллагаанд холбогдож байсан эсэх талаар лавлагаа авч байх. Лавлагаа нь өөрсдийн судалгаа, эсвэл гуравдагч этгээдийн/цагдаагийн тодорхойлолт хэлбэртэй байх бөгөөд ажилд авах процесс гэрээт хамгаалалтын албаар дамжин хийгдэж байсан ч энэ лавлагаа заавал авагдана.</p> | Зөрчлийн менежмент | ЕСБХБ ГШ 2 | Компанийн нөөц | Төслийн нийт хугацаанд | Хамгаалалтын албаны сургалтын мэдээллийг ЕСБХБ-нд хүргүүлсэн байна. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------|----------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| ГШЗ | Нөөцийн үр ашигтай зарцуулалт, Бохирдлоос сэргийлэх ба хяналт | | | | | | |
| 3.1 | Төслийн нарийвчилсан усны баланс боловсруулах. Усыг дахин болон эргүүлэн ашиглах боломжуудыг ихэсгэх. Бороогийн уурхай дахь хүдэр боловсруулах байгууламжийн нарийвчилсан усны балансад хаягдлын далангийн багтаамжийг оруулан тооцох. | Ус ашиглалтын үр ашиг, хяналт | ЕСБХБ ГШ 3 | Компанийн нөөц Шаардлагатай тохиолдолд гадны зөвлөхүүд авах | Төслийн барилгын үе шатнаас өмнө, төслийн нийт хугацаанд | Усны балансын нарийвчилсан загвар хийгдсэн байна. Хяналт шинжилгээний хөтөлбөртэй байна. | |
| 3.2 | Төслийн хаягдлын далангийн өргөтгөлд одоо ашиглагдаж буй менежментийн хөтөлбөрүүд болон олон улсын тэргүүн туршлагын аргуудыг (жишээ нь. Олон улсын Хүнцэлийн менежментийн код) үргэлжлүүлэн хэрэглэх, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах. | Хаягдлын далангийн менежмент | ЕСБХБ ГШ 3 | Компанийн нөөц | Хаягдлын далангийн өргөтгөл болон ашиглалтын үед | Бороогийн хаягдлын далангийн одоогийн хэрэглэгдэж буй менежментийн журмуудыг үргэлжлүүлэн хэрэглэх, шаардлагатай бол шинэчлэх, олон улсын тэргүүн туршлагауудын хэрэглэсэн байна. | |
| 3.3 | Хүлэмжийн хийн нарийвчилсан бүртгэлийг (шууд ба шууд бус ялгаралыг оролцуулан) Төслийн хэмжээнд боловсруулах. Бүртгэлийг жил бүр шинэчлэх. | Хүлэмжийн хийн тайлан | ЕСБХБ ГШ 3 | Компанийн нөөц | Жил бүр | Хүлэмжийн хийн бүртгэл хийгдэж, жил тутам ЕСБХБ-нд тайлагнасан байна. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-----|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------|--------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| 3.4 | Уурхайн ашиглалтын үед усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөнөөс зайлсхийх, уурхайн ашиглалт дууссаны дараа байгалийнхаа жамаар өөрөө өөрийгөө тэтгэн орших газрыг үлдээх зорилгоор хаягдал чулуулаг, ил уурхай, хаягдлын далан болон уурхайн хаалтын зохистой менежментийг хэрэгжүүлэхэд шаардагдах геохимийн нэмэлт шинжилгээ судалгааны ажлуудыг хэрэгжүүлэх. | Хаягдал чулуулгийн менежмент | ЕСБХБ ГШ 3 | Компанийн нөөц Шаардлагатай тохиолдолд гадны зөвлөхүүд авах | Барилгын үе шат эхлэхээс өмнө ба ашиглалтын үе шатанд тогтсон хугацаанд | Уурхайн ашиглалтын болон хаалтын дараах хаягдал чулуулгийн менежментэд шаардлагатай мэдээлэл бий болсон байна. | |
| 3.5 | Гацууртын ордын хүдрийн боловсруулалтыг Бороогийн уурхай дахь Олон улсын хүнцэлийн менежментийн кодын хамрах хүрээнд оруулах. | Хүнцэлийн эрсдлийн менежмент | ЕСБХБ ГШ 3 | Компанийн нөөц Шаардлагатай тохиолдолд гадны зөвлөхүүд авах | Төслийн ашиглалтын үе шат эхэлснээс 2 жилийн дотор эсвэл Олон Улсын Хүнцэлийн Менежментийн Хүрээлэнгийн (ICMI) гэрчилгээ авах аудитын үеэр | Уурхайн ашиглалт явуулахад Олон Улсын Хүнцэлийн Менежментийн гэрчилгээ авагдсан байна. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| 3.6 | <p>Уурхайн нөлөөнд өртсөн гадаргын усыг цэвэрлэх, зайлуулах аргыг тодорхойлох нэмэлт судалгаа, шинжилгээг авч хэрэгжүүлэх. Эдгээр нь Төсөлд тохирсон ус цэвэрлэх аргыг тодорхойлох, зайлуулах хаягдал усны чанар, үүнээс байгалийн ус болон орчны экологид үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг тогтоох зэрэг болно. Эдгээр арга хэмжээг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж гүйцэтгэнэ.</p> <p>Уурхайн хаалтын дараа хэрэгжүүлэх арга хэмжээний шаардлагуудыг тооцсоны үндсэн дээр тохирсон аргуудыг сонгоно.</p> | Уурхайн усны менежмент | ЕСБХБ ГШ 3 | <p>Компанийн нөөц</p> <p>Шаардлагатай тохиолдолд гадны зөвлөхүүд авах</p> | Барилгын үе шат эхлэхээс өмнө болон уурхайн бүхий л үе шатуудад хэрэгжүүлнэ. | Уурхайн ус цэвэрлэх болон зайлуулах тохиромжтой аргуудыг тодорхойлон хэрэгжүүлсэн байх ба зохих хяналт шинжилгээны ажлууд мөн хийгдсэн байна. | |

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| 3.7 | <p>Гадаргын болон газрын доорхи усыг уурхайн болон хаягдал чулуулгын талбайгаар дайруулахгүй байх, гольдрол нь өөрчлөгдсөн урсацын чанар, хэмжээг бууруулахгүй байлгах зорилгоор гадаргын усны урсацын өөрчлөлт болон уурхайн ус шавхалтын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулсан байх.</p> <p>Энэ төлөвлөгөөнд эрх бүхий байгууллагуудтай зөвшилцөн тодорхойлсон нь усны чанарын үзүүлэлтүүдийн хязгаарууд, урсацын хэмжээний зөвшөөрөгдөх доод хэмжээг тусгасан байна.</p> | Уурхайн усны менежмент | ЕСБХБ ГШ 3 | <p>Компанийн нөөц</p> <p>Шаардлагатай тохиолдолд гадны зөвлөхүүд авах</p> | Барилгын үе шат эхлэхээс өмнө болон уурхайн бүхий л үе шатуудад хэрэгжүүлнэ. | Гадаргын усны голдрилын болон уурхайн шавхалтын зохистой аргууд, голдрил нь өөрчлөгдсөн усны чанар болон урсацын доод хэмжээг тодорхойлогдсон байна. | |
| ГШ 4 | Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал | | | | | | |
| 4.1 | Уурхайн тээврийн замын үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл, тэдгээрийн менежмент, аюулгүй ажиллагаа, эрсдлийг бууруулах компанийн арга хэмжээний талаар орон нутгийн иргэд, эрх бүхий байгууллагуудтай тогтмол уулзаж хамтран ажиллах. | Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдлийн менежмент | ЕСБХБ ГШ 4 | Компанийн нөөц | Уурхайн бүхий л үе шатуудад хэрэгжүүлнэ. | Орон нутгийн иргэд, эрх бүхий байгууллагуудтай замын аюулгүй байдлын талаар тогтмол уулзаж хамтран ажилладаг байна. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-----|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------|----------------------------------------------------|----------------------------------|------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| 4.2 | <p>Гал түймэр, тэсрэх дэлбэрэх, хорт бодис асгарах, хүний амь насанд ноцтой гэмтэх учруулах, амь нас эрсдэх зэрэг болон уурхайн үйл ажиллагааны явцад тохиолдож болзошгүй бусад аюулын үеийн Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөг холбогдох эрх бүхий байгууллагууд, иргэдтэй зөвлөлдөн ЕСБХБ-ны шаардлагуудад нийцүүлэн шинэчлэх.</p> <p>Сургалт болон дадлагын сургуулилалт тогтмол хэрэгжүүлэх.</p> | Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны эрсдлийн үр дүнтэй менежмент | Монголын улсын хууль тогтоомж, ЕСБХБ ГШ 4 | Компанийн нөөц | Уурхайн бүхий л үе шатуудад хэрэгжүүлнэ. | <p>Онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөөтэй байна.</p> <p>Сургалтын бүртгэлүүд.</p> <p>Жил тутмын Байгаль орчин, нийгмийн тайлангийн шинэчлэл.</p> | |

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------|--------------------------------------|------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------|
| ГШ 5 | Газар эзэмшил, сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт ба эдийн засгийн шилжилт хөдөлгөөн | | | | | | |
| 5.1 | <p>Нийгмийн Менежментийн Төлөвлөгөөнд орсон малчдын амьжиргаанд нөлөөлөх байдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.</p> <p>Бэлчээр/тариалан сайжруулах ажлыг Сум Хөгжүүлэх Сангаа хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд хийх. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Малчид, фермерүүдыг мал/ тариалангийн ашиг шимийг нэмэгдүүлэхэд нь дэмжин амьжиргаанд нь туслах; • Малчид/тариаланчид хамтран ажиллаж орлогоо болон орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэх санаачлагыг дэмжих; • Бэлчээр, мал аж ахуй, нүүдлийн соёлыг хамгаалан үлдээх. | Амьжиргааны түвшин дордолтыг бууруулах | ЕСБХБ ГШ 5 | Компанийн болон Гэрээт талуудын нөөц | Уурхайн барилгын болон ашиглалтын үе шатуудад хэрэгжүүлнэ. | <p>Төслийн орчим дахь оролцогч талууд, газар ашиглагч нартай тогтмол уулзаж ярилцаж байна.</p> <p>Нийгмийн Менежментийн Төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байна. Хөдөө аж ахуйг дэмжих хөтөлбөрүүдийг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.</p> | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|-------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------|--------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------|--------|
| ГШ 6 | Биологийн олон янз байдал, Амьд байгалийн нөөц баялаг | | | | | | |
| 6.1 | Устгасан ойг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөрийг холбогдох эрх бүхий байгууллагууд, иргэдтэй зөвлөлдөн боловсруулж хэрэгжүүлнэ. Үүнд, одоогийн байгаа ой бүхий газруудын менежментийг сайжруулан хамгаалах, Төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртөөгүй ойг нөхөн сэргээх, уурхайн хаалт нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлууд орж болно. | Ой хамгаалах сайжруулсан менежмент. | ЕСБХБ ГШ 6 | Компанийн болон Гэрээт талуудын нөөц | Уурхайн ашиглалт эхлэхээс өмнө хөтөлбөр боловсруулагдаж, ашиглалтын болон хаалтын дараах үед хэрэгжүүлнэ. | Эрх бүхий байгууллагын баталсан ойг дүйцүүлэн хамгаалах хөтөлбөр боловсруулан хэрэгжсэн байна. | |
| ГШ 8 | Соёлын өв | | | | | | |
| 8.1 | Уурхайн барилгын болон ашиглалтын үед олдсон санамсаргүй олдворын журмыг хэрэгжүүлнэ. | Санамсаргүй олдворуудын менежмент | ЕСБХБ ГШ 8 | Компанийн нөөц, Гэрээт талууд | Уурхайн барилгын болон ашиглалтын үеүдэд | Санамсаргүй олдвор олдсон үед компанийн журам болон хуулийн дагуу арга хэмжээ авагдсан байна. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|--------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------|----------------------------------|--------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------|--------|
| 8.2 | Гацууртын замаас тусгай хамгаалалттай Ноён уулын тахилгат газруудад хүрэх аюулгүй замыг иргэдэд зориулан гаргаж өгөх | Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны менежмент болон соёлын өв бүхий газруудад хүрэх замуудын менежмент | ЕСБХБ ГШ 8, ГШ 4 | Компанийн нөөц, Гэрээт талууд | Уурхайн барилгын болон ашиглалтын үе шатанд | Замуудыг олон нийтийн аюулгүй байдалд эрсдэл учруулахгүйгээр хамгаалан ашиглана. | |
| ГШ 10 | Мэдээллийг ил тод болгох ба Талуудыг татан оролцуулах | | | | | | |
| 10.1 | Төслийн Оролцогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг (ОТТОТ) хэрэгжүүлэх. ОТТОТ-г тодорхой хугацаанд хянан, шаардлагатай шинэчлэлийг хийх. ОТТОТ нь компанийн бусад журмуудтай нэгдсэн байдлаар хийгдэж болно. | Зохистой байдлаар олон нийтийг татан оролцуулж, мэдээллийг ил тод болгоно. | ЕСБХБ ГШ 10 | Компанийн нөөц | БОННУ -г олон нийтэд танилцуулах үед болон Төслийн бүхий хугацаанд | ОТТОТ хэрэгжүүлсэн байна. Олон нийтийг оролцуулсан ажлын бүртгэл. | |

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

| №. | Арга хэмжээ | Байгаль орчин, нийгмийн эрсдлүүд (Хариуцлага/ Гарах үр дүн) | Шаардлагууд (Хуулийн, ЕСБХБ-ы ГШ, Шилдэг туршлага) | Шаардагдах нөөц/төсөв, Хариуцагч | Хугацаа | Хэрэгжилтийг үнэлэх шалгуур | Статус |
|------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------|----------------------------------------------------|----------------------------------|--------------------------------------------------------------------|------------------------------------------------|--------|
| 10.2 | <p>Гадны оролцогч талуудад зориулсан Өргөдөл гомдол барагдуулах албан ёсны механизм боловсруулж хэрэгжүүлэх. Энэ механизмд гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх арга замууд, тэдгээрийг баримтжуулан бүртгэх үйл ажиллагааг тодорхой байдлаар тусгасан байна.</p> <p>Олон нийттэй харилцах холбогдох албан тушаалтнуудтай холбогдох хаягийг уурхайн барилга байгууламжуудын орцны ойролцоо тавих буюу орон нутгийн иргэдэд мэдэгдсэн байна.</p> <p>Гомдол шийдвэрлэх журмуудыг ОТТОТ-нд оруулах ба компанийн цахим хуудсанд мөн байршуулна.</p> | Өргөдөл гомдол барагдуулах менежмент | ЕСБХБ ГШ 10 | Дотоод нөөц бололцоо | БОННУ -г олон нийтэд танилцуулах үед болон Төслийн бүхий хугацаанд | Өргөдөл гомдол барагдуулах механизм хэрэгжинэ. | |